

**Ерөнхийлөгч Дийр Ф.Угдорф**

Тэргүүн Зөвлөлийн хоёрдугаар зөвлөх



## Бурханы ургац

**К**риста хэмээх нэгэн эмэгтэй үрийн жижигхэн компанид ажилладаг байжээ. Тэр ажилдаа дуртай байлаа. Түүний зарсан бяцхан үр болгон ямар нэгэн гайхалтай зүйл—лууван, байцаа эсвэл бүр хүчирхэг том царс мод болон хувирах чадвартай нь гайхшралыг нь маш их төрүүлдэг байжээ.

Криста компьютерийнхаа ард суугаад захиалга аван, асуултуудад хариулах дуртай байв. Гэтэл нэгэн өдөр түүнийг сандаргасан нэг гомдол иржээ.

“Үрнүүд ургахгүй байна. Би хоёр сарын өмнө эдгээрийг худалдаж авсан, юу ч ургасангүй” хэмээн үйлчлүүлэгч хэлэв.

“Та тэднийг сайн хөрсөнд суулгаж, хангалттай усалж, нарны гэрэлд байлгасан уу?” гэж Криста асуулаа.

“Үгүй ээ, гэхдээ би хийх зүйлээ хийсэн. Би үр худалдаж авсан. Тэр үр чинь ургах нь *баталгаатай* биз дээ” хэмээн үйлчлүүлэгч хариулав.

“Гэхдээ та үрийг тариагүй гэж үү?”

“Мэдээж үгүй. Тэгвэл миний гар бохир болно шүү дээ.”

Криста энэ талаар бодож, тарих зааврыг бичих хэрэгтэй юм байна гэж шийдэв. Тэрээр, хамгийн эхний заавар нь: “Та үрийг нахиалуулахын тулд тарих зааварчилгааг дагах ёстой. Та үрийг тавиур дээр тавьснаар ургана хэмээн найдаж болохгүй” гэж бичихээр шийджээ.

Удалгүй түүнийг сандаргасан дараагийн гомдол гарлаа.

“Үрнүүд жимсээ өгөхгүй байна” хэмээн нэгэн үйлчлүүлэгч гомдоллов.

Криста хариуд нь “Та үрээ сайн хөрсөнд суулгасан уу? Зохих хэмжээнд усалж, нарны гэрэлд байлгасан уу?” гэлээ.

“Тэгэлгүй яхав, би савлагаан дээр байсны дагуу бүгдийг хийсэн. Гэсэн ч ургасангүй” гэж үйлчлүүлэгч зүтгэв.

“Ер нь ямар нэгэн өөрчлөлт гарсан уу? Үр нахиалсан уу?”

“Юу ч болоогүй. Би заасны дагуу тарьсан. Оройн хоолондоо улаан лооль авах нь дээ гэж найдаж байлаа. Миний урам үнэхээр хугарч байна” хэмээн үйлчлүүлэгч хэллээ.

“Криста хариуд нь “Байзна даа! Та тэгэхээр үрээ өнөөдөр тарьсан гэх гээд байна уу?”

“Битгий инээдтэй зүйл ярь л даа. Би долоо хоногийн өмнө тарьсан. Би эхний өдөртөө л улаан лооль авна гэж найдсан юм биш. Би тэвчээртэй байсан. Чамд гэж хэлэхэд, энэ хугацаанд би маш их усалж, маш их хүлээсэн” хэмээн үйлчлүүлэгч хариулав.

Криста тэгэхэд өөр нэг заавар нэмэх хэрэгтэй юм байна гэдгээ мэдэв: “Эдгээр үр нь биологийн хуульд захирагдана. Хэрэв та үрээ өглөө нь суулгаад, долоо хоногийн дараа улаан лооль иднэ гэж найдаж байвал таны урам хугарах болно. Та тэвчээртэй байж, байгалийн бүтээл өөрөө бий болохыг хүлээх ёстой.”

Кристад өөр нэг гомдол ирэх хүртэл бүх зүйл сайхан байв.

Нэгэн үйлчлүүлэгч: “Би танай үрнүүдэд үнэхээр урам хугарч байна. Би савлагаан дээрх зөвлөмжийн дагуу тарьсан. Суулгасан үрээ усалж, наранд байлгаж, ургацаа өгтөл хүлээсэн” гэлээ.

“Та бүх зүйлийг зөв хийсэн бололтой” хэмээн Криста хэлэв.

Үйлчлүүлэгч: “Бүх зүйл дажгүй байлаа. Гэвч миний хураасан зүйл нь нарийн хулуу!” гэлээ.

“Миний бүртгэлээс харахад тэр чинь таны захиалсан үрнүүд байна шүү дээ” гэж Криста хэлэв.

“Гэхдээ би нарийн хулуу хүсээгүй; зүгээр л хулуу хүссэн шүү дээ!”

“Би ойлгосонгүй.”

“Би — өнгөрсөн жил хулуу тарьсан талбайдаа, яг тэр хөрсөнд үрээ суулгасан. Би үрээ ямар гайхалтай хулуунууд болон ургахыг нь хэлж, магтаж байлаа. Гэвч том, бөөрөнхий, улбар шар хулууны оронд урт ногоон хулуу гарч ирсэн. Бүр маш олноороо шүү!”

Криста тэгэхэд магадгүй, зөвхөн заавар нь хангалттай биш, харин үндэслэлийг нь бичих шаардлагатай байсныг мэдэв: “Таны үр, суулгац болон тариалалтын хугацаа, ялгаж тарих зэргээс ургац шалтгаалдаг.”

## Ургацын хууль

Төлөөлөгч Паул, Бурханы ургацын тухай заасан:

“Бүү мэхлэгд. Бурхан элэг доог болохгүй. Хүн юу тарина, түүнийгээ л хурааж авдаг.

“Яагаад гэвэл өөрийнхөө махан биед таригч нь махан биеэсээ ялзралыг хурааж авна. Харин Сүнсэнд таригч нь Сүнснээс мөнх амийг хурааж авна.

“Сайныг үйлдэхдээ зүрхшээхгүй байцгаая. Учир нь хэрэв бид шантрахгүй байвал цаг нь болохоор хурааж авна” (Галат 6:7–9).

Эдүгээ Их Эзэн бидэнд илүү мэргэн ухаан, гярхай байдал, энэхүү өөрчлөгдөшгүй хуулийг өгсөн:

“Энэ дэлхийн сууринаас өмнө, дээр нь бүх адислал тулгуурлагдсан хууль тэнгэрт эргэлт буцалтгүйгээр тогтоогдсон болой—

“Мөн бид ямар ч адислалыг Бурханаас авлаа гэхэд, энэ нь тулгуурлагдсан тэрхүү хуульд дуулгавартай байснаар буюу” (С ба Г 130:20–21).

Бид юу тарьснаа хурааж авдаг.

Бурханы ургац бол төсөөлшгүй алдар суутай билээ. Өөрийг нь хүндэлдэг хүмүүст Түүний өгөөмөр адислалууд нь “шахагдсан, чигжсэн мөн бялхсан хэмжээтэйгээр хормой дээр чинь асгарах болно. Учир нь өөрсдийнхөө хэмжүүрийн жишгээр та нар хариуд нь хэмжигдэх болно” (Лук 6:38).

Газрын үрийг ургуулахтай адил тэнгэрийн олон адислалыг авахад ч бас хичээл зүтгэл, тэвчээр шаардана. Бид өөрсдийн шашныг тавиур дээр тавьчхаад сүнслэг адислал хурааж авна хэмээн найдаж болохгүй. Харин бид сайн мэдээний жишгүүдийг гэр бүлийнхээ өдөр тутмын амьдралд тарьж мөн арчлах юм бол, бидний хүүхдүүд өөрсөд нь болон хойшдын үр удамынхандаа агуу үнэ цэнэ бүхий сүнсний үр жимсийг ургуулахуйц өсөх өндөр магадлал бий.

Бидний залбиралд Бурханы хариулт үргэлж шууд ирдэггүй — заримдаа бүр ирэхгүй мэт байдаг— гэвч Бурхан хүүхдүүдээ юу нь хамгийн сайн бэ гэдгийг мэддэг. Үнэхээр бид нэг л өдөр илүү тодорхой харах болно; тэгээд тэр өдөр бид тэнгэрийн сайхан сэтгэл, өгөөмөр занг таних болно.

Тэр хүртэл бид ариун сайхан амьдралаар амьдрахын тулд Багш, Аврагчийнхаа жишээг дагах нь бидний зорилго мөн баяр баясал байх ёстой. Тэгснээр Бурханы үнэлшгүй адислалын амлагдсан, үнэт ургац биднийх байх болно.

Бид юу тарьснаа хурааж авдаг.

Энэ бол тэнгэрийн хууль.

Энэ нь Бурханы ургацын хууль юм.

---

## ЭНЭХҮҮ ЗАХИАСААС ЗААХ НЬ

Айлчилсан хүмүүстэйгээ хамт Бурханы ургацын хууль нь хэрхэн харилцаа холбоо, үг яриа, гэрчлэл эсвэл ажил мэргэжил болон боловсролын зорилгод хамаатай болох талаар ярилц. Та мөн Сургаалт үгс 11:18; 2 Коринт 9:6; мөн Алма 32 зэрэг энэхүү хуультай холбогдох судруудыг уншиж мөн эргэцүүлэн бодож болно. Тэднийг өмнөх зорилгоо нягталж, зөв шударга, үр дүнд хүрэх шинэ зорилгууд тавихад нь урамшуулан дэмж. Урт хугацааны зорилгодоо хүрэхийн тулд тууштай байх төлөвлөгөө боловсруулахад нь тэдэнд тусал.

## ХҮҮХДҮҮДЭД ЗОРИУЛАВ

### Ургацаа төлөвлө

**Б**урханы ургацын хууль нь, хэрэв бид ямар нэг зүйлийг хожим авахыг хүсвэл түүнийхээ төлөө одоо ажиллах хэрэгтэй гэсэн үг юм. Тиймээс бид ногоо тарихыг хүсвэл эхлээд үрээ суулгаж, усалж мөн зэрлэг ургамлаас хамгаалах хэрэгтэй. Үүнийг хийхгүй бол бид хожим нь ургацгүй байх болно!

Таны амьдралдаа олж авахыг хүсэж болох зарим сайн “үр жимс”-ийг дор жагсаав. Энэ сард эдгээр адислалыг авахад тань танд туслах хийж чадах зарим зүйлээ бичнэ үү.

- Аз жаргалтай гэр орон
- Боловсрол
- Сайн найзууд
- Баптисм болон гишүүний баталгаа
- Есүс Христийн талаарх гэрчлэл



# Есүс Христийн тэнгэрлэг зорилго: Мессиа

*Энэ материалыг залбирч судлан, хуваалцах зүйлээ мэдэж авахаар эрэлхийл. Аврагчийн амьдрал болон зорилгыг ойлгох нь таны Түүнд итгэх итгэлийг хэрхэн нэмэгдүүлж мөн айлчлагч багшлалтаар дамжуулан харж ханддаг хүмүүсийн тань амьдралыг хэрхэн адислах вэ? Дэлгэрэнгүй мэдээллийг [reliefsociety.lds.org](http://reliefsociety.lds.org) хаягаас үзнэ үү.*

Итгэл, гэр бүл, халамж

*Энэ бол Аврагчийн зорилгын онцлог талуудын тухай Айлчлагч багшийн цуврал захиасуудын хэсэг юм.*

**Б**ид “Ариун Мессиагийн сайн үйл мөн нигүүлсэл, мөн ач ивээлээр” (2 Нифай 2:8) дамжуулан Бурханы дэргэд байж чадна хэмээн судрууд заадаг. *Messiah* гэдэг нь “Тослогдсон” гэсэн утгатай арамей болон еврей үг юм. Шинэ Гэрээнд Есүс нь Христ гэж нэрлэгддэг нь грек хэлээр *Мессиа* гэсэнтэй адил юм. Энэ нь . . . тослогдсон Бошиглогч, Прист, Хаан мөн Чөлөөлөгч гэсэн утгатай.”<sup>1</sup>

Арванхоёр Төлөөлөгчийн чуулгын ахлагч Жэффри Р.Холланд: “[Есүс Христ] бол дэлхий дээр эздийн Их Эзэн мөн хаадын Хаанаар хаанчлахаар нэгэн өдөр эцсийн алдар суунд ирэх Изриалын Ариун Нэгэн, Мессиа гэдгийг би мэднэ. Хүн аврагдаж болох өөр нэр тэнгэрийн дор өгөгдөөгүй гэдгийг би мэднэ”<sup>2</sup> хэмээн гэрчилсэн.

Тэргүүн Зөвлөлийн хоёрдугаар зөвлөх, ерөнхийлөгч Дийтр Ф.

Угдорф хэлэхдээ: “[Есүс Христ] бол амлагдсан Мессиа. Тэр төгс амьдралаар амьдарч, бидний нүглийг цагаатгасан. Тэрээр үүрд бидний талд байх болно. Тэр бидний тулаанд тулалдана. Тэр бол бидний найдвар; Тэр бол бидний аврал; Тэр бол зам нь юм”<sup>3</sup> гэжээ.

## Нэмэлт судрууд

Иохан 1:38–41; 4:25–26, 40–42;  
2 Нифай 6:13; 25:16–17

## Судруудаас

Мессиагийн хувьд Христийн үүргийг Түүний эмэгтэй шавь нар нь гэрчилсэн. Магдалын Мариа Есүс Христийн шавь байжээ. Тэрээр Христийн амилалтын өглөө “булшны амнаас хадыг зайлуулсан байхыг” харсан анхны хүн байв. Түүний бие булшинд байхгүй байгааг мэдээд тэр “булшны гадаа зогсоод уйлж байв.”

Тэгээд “тэр эргэхдээ Есүсийн зогсож байхыг харсан боловч таньсангүй.

“Есүс түүнд, Эмэгтэй чи юунд уйлна вэ? Чи хэнийг хайна вэ? гэж асуув. Түүнийг цэцэрлэгч байна гэж бодоод тэр Түүнд, Эзэнтэн, хэрэв та Түүнийг авсан бол хаана тавьснаа надад хэлнэ үү? Би Түүнийг авах гэсэн юм гэв.

“Тэтэл Есүс, Мариа гэлээ. Мариа эргэнгүүтээ Түүнд еврейгээр Рабуни! (Багш гэсэн утгатай) гэжээ.” Мариа Түүнийг цэцэрлэгч биш харин Есүс Христ, Мессиа гэж таньсан юм. Иохан 20:1–17-ийг үзнэ үү.)

## Эшлэлүүд

- Судруудын удирдамж, “Мессиа”; [scriptures.lds.org](http://scriptures.lds.org).
- Жэффри Р.Холланд, “Цорын ганц үнэн Бурхан болон Түүний илгээсэн Есүс Христ,” *Лиахона*, 2007 оны 11-р сар, 42
- Дийтр Ф.Угдорф, “Шавь болох зам,” *Лиахона*, 2009 оны 5-р сар, 78.

## Үүнийг эргэцүүлэн бод

Мессиагийн хувьд Аврагчийн үүргийг ойлгох нь яагаад чухал вэ?